



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

**Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 18 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга/А.Сүхболд/-т даалгасугай.

3. 2022 оны А/40 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 сарын 15-ны өдрийн 1105 дугаар тогтоолын хавсралт



Багахангай дүүргийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол

1. Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

№	Дүүрэг	Хороо	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ [m2]	Улирал I	Улирал II	Улирал III	Улирал IV
1	Багахангай	1-р хороо	Өндөртолгой Спорт хорооны баруун талд	Усан бассейн, боулингийн төвийн цахилгаан хангамжийн дэд станц барих	60	+	+	+	+
2	Багахангай	2-р хороо	"Трансгайд сервис" ХХК-ны хойд талд, Улсын чанартай авто замын баруун талд	Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж	300000	+	+	+	+